

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2026/013/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот</p> <p>2026 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: В.Жавзмаа Утас: 70357955 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. «cityname»

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.02.12 № 45
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Орхон аймгийн хөрөнгө оруулалтаар 145,850.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлснийг санхүүгийн тайланд тусгасан байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны А/936 дугаар захирамжаар 855,519.0 мянган төгрөгийн хөрөнгийг Орон нутгийн өмчийн газарт шилжүүлсэн байна.

Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын гол асуудал

Тус газар нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2018 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/174 дугаар тушаалаар баталсан

612505292

“Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөж байна. НБББББ-т шинэчлэн баталсан хууль, тогтоол, дүрэм журмын өөрчлөлтийг тусгаагүйгээс санхүүгийн тайлан үнэн зөв, иж бүрэн илэрхийлэхэд эрсдэл үүсэхээр байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилт, 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, биелэлтийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар 91.0 хувиар дүгнэсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	38,316,022.54	48,866,705.00
33	АВЛАГА	1,515,612.54	29,548,345.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	25,347.54	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	1,040,000.00	29,098,080.00
335	Бусад авлага	450,265.00	450,265.00
3351	Байгууллагаас авах авлага	450,265.00	450,265.00
35	БАРАА МАТЕРИАЛ	36,800,410.00	19,318,360.00
351	Түүхий эд материал	1,604,000.00	963,700.00
35110	Тусгай зориулалттай материал	247,000.00	398,700.00
35130	Эм боох материал	1,357,000.00	565,000.00
354	Хангамжийн материал	35,196,410.00	18,354,660.00
35410	Бичиг хэргийн материал	345,000.00	-
35420	Аж ахуйн материал	31,633,910.00	18,354,660.00
35440	Түлш, шатах тослох материал	667,500.00	-
35470	Бусад хангамжийн материал	2,550,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,646,425,091.69	1,233,938,584.72
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,646,425,091.69	1,233,938,584.72
392	Биет хөрөнгө	1,525,886,091.69	961,698,584.72
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,491,822,805.00	796,441,215.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(196,554,051.42)	(120,899,472.90)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,998,000.00	74,998,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(74,998,000.00)	(74,998,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	529,717,753.00	597,777,790.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(368,107,290.07)	(362,980,547.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	216,469,310.46	168,409,795.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(147,462,435.28)	(117,050,196.36)
393	Биет бус хөрөнгө	120,539,000.00	272,240,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	132,341,273.00	274,694,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(11,802,273.00)	(2,454,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,684,741,114.23</u>	<u>1,282,805,289.72</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,040,000.00	1,605,411.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,040,000.00	1,605,411.00
413	Өглөг	1,040,000.00	1,605,411.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	540,411.00
4136	Бусад өглөг	1,040,000.00	1,065,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	25,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,040,000.00	1,040,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,683,701,114.23	1,281,199,878.72
51	Засгийн газрын хувь оролцоо	1,683,701,114.23	1,281,199,878.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	604,452,423.60	604,452,423.60
51101	Өмч: - төрийн	604,452,423.60	604,452,423.60

512	Хуримтлагдсан үр дүн	907,035,750.10	624,779,317.62
51210	Өмнөх үеийн үр дүн	907,035,750.10	1,027,280,553.13
51220	Тайлант үеийн үр дүн	-	(402,501,235.51)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	172,212,940.53	51,968,137.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,684,741,114.23</u>	<u>1,282,805,289.72</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,820,273,075.08	3,009,032,113.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	371,911,538.00	482,878,132.00
120	Нийтлэг татварын бус орлого	371,911,538.00	482,878,132.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	371,911,538.00	482,808,132.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	87,026,000.00	80,316,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	284,885,538.00	402,492,132.00
120009	Бусад орлого	00.00	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,448,361,537.08	2,526,153,981.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,957,720,000.00	1,975,624,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,957,720,000.00	1,975,624,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	490,641,537.08	513,871,901.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	447,500,897.08	507,521,901.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,140,640.00	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	350,000.00
1330	Төсвийн захирагчдаас	00.00	36,658,080.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	36,658,080.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,559,755,055.24	2,711,815,416.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,559,755,055.24	2,711,815,416.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,335,728,814.24	2,521,537,418.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,831,928,830.30	1,982,359,411.07
210101	Үндсэн цалин	847,155,262.34	874,375,662.83
210102	Нэмэгдэл	632,229,524.82	727,694,714.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	183,544,635.91	249,252,950.61
210104	Урамшуулал	168,999,407.23	131,036,082.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	218,793,792.11	238,027,739.54
210201	Тэтгэврийн даатгал	152,778,815.29	164,773,191.54
210202	Тэтгэмжийн даатгал	17,090,663.72	19,599,304.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,416,299.90	9,911,020.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,388,352.38	8,708,139.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,119,660.82	35,036,085.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,286,040.38	35,496,997.07
210301	Гэрэл, цахилгаан	9,231,622.53	8,010,794.79
210302	Түлш, халаалт	12,798,492.78	12,118,632.22
210303	Цэвэр, бохир ус	12,255,925.07	15,367,570.06
2104	Хангамж, бараа материалын зардал	29,995,474.42	34,519,594.00
210401	Бичиг хэрэг	7,336,000.00	2,005,500.00
210402	Тээвэр, шатахуун	10,686,497.00	6,957,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,977,377.42	4,121,244.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	894,800.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,375,600.00	5,421,100.00

210408	Бараа материал акталсны зардал	3,725,200.00	15,414,250.00
2105	Нормативт зардал	36,951,320.00	26,489,140.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,500,000.00	00.00
210502	Хоол, хүнс	33,549,320.00	26,489,140.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	902,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,571,200.00	6,002,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	143,900.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	2,550,000.00
210604	Урсгал засвар	6,427,300.00	3,452,750.00
2107	Томилолт, зочны зардал	1,962,000.00	5,996,500.00
210702	Дотоод албан томилолт	1,962,000.00	5,996,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,062,866.13	8,031,930.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,383,390.13	4,108,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,411,200.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	260,000.00	306,130.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	113,200.00	101,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,440.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	716,200.00	1,440,600.00
210807	Газрын төлбөр	1,992,416.00	2,041,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	161,020.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	145,177,290.90	184,613,357.09
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,934,750.00	62,709,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,730,000.00	7,020,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	91,512,540.90	114,883,607.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	224,026,241.00	190,277,997.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	220,478,741.00	83,805,837.82
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	23,365,054.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	38,477,852.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	209,536,341.00	21,962,931.82
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,942,400.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	106,472,160.04
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,547,500.00	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,547,500.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	260,518,019.84	297,216,696.37
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	699,717,931.88
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	699,717,931.88
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-699,717,931.88
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	260,518,019.84	-402,501,235.51

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,538,935,037.08	2,606,539,981.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,026,000.00	80,386,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	87,026,000.00	80,386,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	87,026,000.00	80,316,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	87,026,000.00	80,316,000.00
120009	Бусад орлого	-	70,000.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,451,909,037.08	2,526,153,981.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,957,720,000.00	1,975,624,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,957,720,000.00	1,975,624,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	494,189,037.08	513,871,901.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	447,500,897.08	507,521,901.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,140,640.00	6,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,547,500.00	350,000.00
1330	Төсвийн захирагчдаас	-	36,658,080.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	36,658,080.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2,526,968,837.08	2,606,539,981.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,526,968,837.08	2,606,539,981.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,258,786,143.88	2,388,203,903.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,831,928,830.30	1,982,359,411.07
210101	Үндсэн цалин	847,155,262.34	874,375,662.83
210102	Нэмэгдэл	632,229,524.82	727,694,714.89
210103	Унаа хоолны хөнгөлөлт	183,544,635.91	249,252,950.61
210104	Урамшуулал	168,999,407.23	131,036,082.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	218,819,139.65	238,002,392.00
210201	Тэтгэврийн даатгал	152,804,162.83	164,747,844.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,090,663.72	19,599,304.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,416,299.90	9,911,020.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,388,352.38	8,708,139.00
210205	Эрүүл мэндийн даатгал	32,119,660.82	35,036,085.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,286,040.38	35,496,997.07
210301	Гэрэл, цахилгаан	9,231,622.53	8,010,794.79
210302	Түлш, халаалт	12,798,492.78	12,118,632.22
210303	Цэвэр, бохир ус	12,255,925.07	15,367,570.06
210304	Байрны түрээс	-	-
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	29,139,477.42	17,608,333.00
210401	Бичиг хэрэг	7,681,000.00	1,635,500.00
210402	Тээвэр, шатахуун	10,777,500.00	6,122,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,977,377.42	3,580,833.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	894,800.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,808,800.00	5,669,100.00
2105	Нормативт зардал	39,849,320.00	26,489,140.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,500,000.00	-
210502	Хоол, хүнс	33,549,320.00	26,489,140.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,800,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,833,200.00	3,762,750.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	855,900.00	-
210602	Тавилга	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,550,000.00	-
210604	Урсгал засвар	6,427,300.00	3,762,750.00
2107	Томилолт, зочны зардал	1,962,000.00	5,996,500.00
210701	Гадаад албан томилолт	-	-
210702	Дотоод албан томилолт	1,962,000.00	5,996,500.00

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,303,386.13	8,758,630.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,784,930.13	4,560,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,411,200.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	260,000.00	306,130.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	113,200.00	101,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,440.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	716,200.00	1,715,600.00
210807	Газрын төлбөр	1,992,416.00	2,041,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,664,750.00	69,729,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,934,750.00	62,709,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,730,000.00	7,020,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	268,182,693.20	218,336,077.86
2132	Бусад урсгал шилжүүлэг	220,478,741.00	83,805,837.82
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	23,365,054.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	38,477,852.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	209,536,341.00	21,962,931.82
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,942,400.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	44,156,452.20	134,530,240.04
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,547,500.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,547,500.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,966,200.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,966,200.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,966,200.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	11,966,200.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,966,200.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(11,966,200.00)	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	604,452,423.60	172,212,940.53	907,035,750.10	1,683,701,114.23
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	604,452,423.60	172,212,940.53	907,035,750.10	1,683,701,114.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	120,244,803.03	120,244,803.03
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	604,452,423.60	172,212,940.53	1,027,280,553.13	1,803,945,917.26
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(120,244,803.03)	-	(120,244,803.03)
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(402,501,235.51)	(402,501,235.51)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	604,452,423.60	51,968,137.50	624,779,317.62	1,281,199,878.72

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Татаас, санхүүжилтийн орлого	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,095,686,800.00	1,949,537,842.24	146,148,957.76	93.03
УРСГАЛ ЗАРДАЛ	2,095,686,800.00	1,949,537,842.24	146,148,957.76	93.03
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,019,374,200.00	1,889,097,058.42	130,277,141.58	93.55
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,637,508,800.00	1,612,124,152.35	25,384,647.65	98.45
Үндсэн цалин	775,690,900.00	787,343,359.14	- 11,652,459.14	101.50
Нэмэгдэл	508,602,900.00	480,981,356.81	27,621,543.19	94.57
Унаа хоолны хөнгөлөлт	230,071,800.00	223,958,573.66	6,113,226.34	97.34
Урамшуулал	123,143,200.00	119,840,862.74	3,302,337.26	97.32
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	204,409,000.00	196,260,306.00	8,148,694.00	96.01
Тэтгэврийн даатгал	139,101,000.00	135,479,000.00	3,622,000.00	97.40
Тэтгэмжийн даатгал	16,372,500.00	15,969,276.00	403,224.00	97.54
ҮОМШӨ-ний даатгал	8,195,500.00	8,083,176.00	112,324.00	98.63
Ажилгүйдлийн даатгал	8,148,100.00	7,345,690.00	802,410.00	90.15
Эрүүл мэндийн даатгал	32,591,900.00	29,383,164.00	3,208,736.00	90.15
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57,694,800.00	35,496,997.07	22,197,802.93	61.53
Гэрэл, цахилгаан	14,721,500.00	8,010,794.79	6,710,705.21	54.42
Түлш, халаалт	25,763,900.00	12,118,632.22	13,645,267.78	47.04
Цэвэр, бохир ус	17,209,400.00	15,367,570.06	1,841,829.94	89.30
Хангамж, бараа материалын зардал	6,262,600.00	5,306,333.00	956,267.00	84.73
Бичиг хэрэг	1,466,500.00	1,285,500.00	181,000.00	87.66

Тээвэр, шатахуун	1,348,200.00	1,192,900.00	155,300.00	88.48
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,806,000.00	1,660,833.00	145,167.00	91.96
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	520,400.00	240,000.00	280,400.00	46.12
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,121,500.00	927,100.00	194,400.00	82.67
Нормативт зардал	60,900,000.00	26,489,140.00	34,410,860.00	43.50
Хоол, хүнс	60,900,000.00	26,489,140.00	34,410,860.00	43.50
Эд хогшил, урсгал засварын зардал	2,549,500.00	265,000.00	2,284,500.00	10.39
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,284,500.00	-	2,284,500.00	-
Урсгал засвар	265,000.00	265,000.00	-	100.00
Томилолт, зочны зардал	8,137,700.00	4,396,500.00	3,741,200.00	54.03
Дотоод албан томилолт	8,137,700.00	4,396,500.00	3,741,200.00	54.03
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,911,800.00	8,758,630.00	33,153,170.00	20.90
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,578,500.00	4,560,200.00	28,018,300.00	14.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,444,400.00	-	1,444,400.00	-
Даатгалын үйлчилгээ	323,900.00	306,130.00	17,770.00	94.51
Тээврийн хэрэгслийн татвар	101,900.00	101,900.00	-	100.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	96,400.00	33,000.00	63,400.00	34.23
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,302,900.00	1,715,600.00	3,587,300.00	32.35
Газрын төлбөр	2,063,800.00	2,041,800.00	22,000.00	98.93
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,312,600.00	60,440,783.82	15,871,816.18	79.20
Бусад урсгал шилжүүлэг	76,312,600.00	60,440,783.82	15,871,816.18	79.20
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,137,000.00	38,477,852.00	1,659,148.00	95.87
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,175,600.00	21,962,931.82	14,212,668.18	60.71
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	-	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,016,795,700.00	2,044,621,236.02	- 27,825,536.02	101.38
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,925,895,700.00	1,964,305,236.02	- 38,409,536.02	101.99
Улсын төсвөөс санхүүжих	1,925,895,700.00	1,964,305,236.02	- 38,409,536.02	101.99
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	90,900,000.00	80,316,000.00	10,584,000.00	88.36
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,900,000.00	80,316,000.00	10,584,000.00	88.36
АЖИЛЛАГСДЫН ТОО	50.00	50.00	-	100.00
Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	29.00	29.00	-	100.00
Үйлчлэх ажилтан	20.00	20.00	-	100.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 220,060.4 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Аудитаар нийт 10,475.4 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 400.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 2,171.7 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 7,903.7 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өглөө.

3.1 Төлбөрийн акт

Ахмадын сангаас ахмадуудын дурсамж контент бүтээхэд 400.0 мянган төгрөгийн зарцуулсан зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Албан шаардлага

Орон нутгийн төсвөөс албан хаагчдын орон нутгийн нэмэгдэлд олгосон санхүүжилтээс 2,171.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төрийн захиргааны 3 албан хаагчид холбогдох дээд байгууллагын шийдвэргүйгээр 6,062.1 мянган төгрөгийн мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57.1-д "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", 57.2.2-т "захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс", Төсвийн тухай хуулийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж : Албан хаагчдад мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох асуудлыг эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх.

2. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал /210806/-аас 1,023.6 мянган төгрөгийн камер бичигч, лангийн утас худалдан авч, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал /210801/-аас 788.0 мянган төгрөгийн байгууллагын албан бичгийн хэвлэмэл хуудас хэвлүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын 210801-д "Гуравдагч этгээдийн үйлчилгээг худалдан авахад төлөх энэ бүлэг/2108/-д зааснаас бусад ажил, үйлчилгээний төлбөр хураамжууд энд хамаарна", 210806-д "Компьютерын хэрэглээний программуудын эрхийн төлбөр, лицензийн төлбөр, тэдгээрийн засвар үйлчилгээг гуравдагч этгээдээс худалдан авах төлбөр энд хамаарна" заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж : Мэдээлэл технологийн үйлчилгээний зардал, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг зориулалтын дагуу зарцуулах.

3. Урсгал зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ахмадын амралтын зардлын санхүүжилтээс 30.0 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27-д “орон нутгийн төсөв” гэж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, тухайн шатны төсөвт харьяалагдах ерөнхийлөн захирагчийн бүрдүүлж, хуваарилан зарцуулах төсвийг;” Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж : Орон нутгаас олгосон санхүүжилтийн тооцоог аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хийж, үлдэгдлийг төсөвт буцаан төвлөрүүлж байх.

4. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үлдэх өртөггүй 159 нэр төрлийн 278,057.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн дахин ашиглах эсэх талаар шийдвэр гаргаагүй, ашиглалтын хугацааг тогтоогоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, аудитын үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж : Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг тухай бүр холбогдох байгууллагаар шийдвэр гаргуулж, дахин үнэлж, данс бүртгэлд тусгах.

5. Санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын 2025 оны санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлэхдээ санхүүгийн тайлангийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын нэгдүгээр хавсралт "Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын 1.3-т "Төсвийн байгууллага нь тодруулбал зохих мэдээллийг заавал тодруулна" гэж заасантай нийцэхгүй, аудитын иж бүрэн байдал, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж : Санхүүгийн тайлангийн тодруулга тайланг зохих журмын дагуу бэлтгэж байх.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХҮГ	5	220,060.4	1	199,706.8	4	20,353.6	5	220,060.4				
Дүн	5	220,060.4	1	199,706.8	4	20,353.6	5	220,060.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ХХҮГ	7	10,475.4	1	400.0	1	2,171.7	5	7,903.7				
Дүн	7	10,475.4	1	400.0	1	2,171.7	5	7,903.7				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ХХҮГ								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ХХҮГ								
Дүн								
Нийт дүн								

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			